

**ТҮРЭГ, МОНГОЛ ХЭЛНИЙ ҮЙЛТ НЭРИЙН ХЭЛЛЭГИЙН  
ШИЛЖИЛТ БА ЦӨМИЙН ХЭМЖИГДЭХҮҮНИЙ ТУХАЙ**

М. Ууганбаяр\*

Ф. Карабүлүт түрэг хэлний энгийн бүтэцтэй өгүүлэхүүнтэй хувилсан өгүүлбэрээс өгүүлбэрийн гишүүд шилжиж хувирсны үр дүнд үйлт нэрийн хэллэг нь онцлог бүтэцтэй болдгийг судлаачид түрэг хэв маягийн хэллэг гэж нэрлэдгийг дурдаад түрэг хэлний үйлт нэрийн хэллэгийн бүтэц нь англи гэх мэт хэлнийх лүгээ адил төгсөх буюу хувилсан тодорхой төлөвт хэллэг бус харин үйлт нэрийн нөхцөлийг авсан үл хувилах тодорхой бус төлөвт өгүүлэхүүнтэй гишүүн өгүүлбэр юм уу доод хэллэг/subordinate clause/ болно гэжээ /Карабүлүт 2009:95/

Ф. Карабүлүт англи хэлний хоёр үйлт нэрийн хэллэгийг баримт болгон харуулж бүтцийг нь тайлбарласныг бид тодруулан үзвэл, англи хэлний үйлт нэрийн хэллэг хувиргал буюу шилжилт хэрэгжихээс өмнө гүн бүтцэнд байгаа гишүүн өгүүлбэр нь

*I saw the man* гол өгүүлбэр/matrix sentence/

*The man was coming* гишүүн өгүүлбэр/subordinate clause/

*I saw the book* гол өгүүлбэр

*You wrote the book* гишүүн өгүүлбэр

гэсэн байдалтай байх бөгөөд эдгээр гишүүн өгүүлбэр буюу хэллэгээс үйлт нэрийн хэллэгтэй бүтцийн өгүүлбэр үүсгэхэд

**I saw [нх the man [нг who [хх was coming]]]**

**I saw [нх the book [нг which [хх you wrote]]]**

гэсэн шиг бүтэц холбох төлөөний үг буюу өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн шууд тусагдахууныг орлох үгээр хувилсан үйл үгтэй гишүүн өгүүлбэрээр үүснэ. /Карабүлүт 2009:97/ Энд эхний өгүүлбэрт гүн бүтцэд өгүүлбэрийн *the man* гэсэн гишүүн *who*-ээр илэрч хоёр дахь өгүүлбэрт гүн бүтцэд *the book* гэсэн гишүүн *which* гэсэн холбох төлөөний үгээр илэрч баруунаас зүүн тийш шилжих бөгөөд өгүүлбэр нэрийн хэлхэц болж хувирна. Энд эхний үйлт нэрийн хэллэгтэй бүтцэд өнгөн бүтцэд тодотгол болох

\* МУИС-ийн МХСС-ийн Хэл шинжлэлийн тэнхим

*the man* хэмээх үг гүн бүтэцдээ буюу *The man was coming* гэсэн гишүүн өгүүлбэрт өгүүлэгдэхүүн болж байна. Харин дараачийн үйлт нэрийн хэллэгтэй бүтцэд *the book* шилжин хувирч хэлхэцийн орой буюу цөм болох ба гүн бүтэцдээ буюу *You wrote the book* гэсэн гишүүн өгүүлбэрт шууд тусагдахуун болж байна.

Бид бүхэн энэ удаа Ф. Карабүлүтийн дээрх англи хэлний жишээг түрэг хэлнээ буулгасныг монгол хэлнийхтэй дүйлгэн харьцуулж, мөн түүний түрэг жишээтэй холбон авч ярьсан тайлбарыг монгол хэлний үйлт нэрийн хэллэгийн хувиргал буюу шилжилтийн баримт хэмээн тооцож дэлгэрүүлэн үзье.

Тү.

*Ben adami gordum*

*Adam geldi*

Ben [sfc gelen adami] gordum

Mo.

*Би хүн харсан*- гол өгүүлбэр

*Хүн ирсэн*- гишүүн өгүүлбэр

Би [үнхл ирсэн хүнийг ] харсан.

Энд гол ба гишүүн өгүүлбэрт нэг дундын махбод байгаа бөгөөд гол өгүүлбэрт шууд тусагдахуун болж буй түрэг хэлний *adam* монгол хэлний *хүн* хэмээх үг гишүүн өгүүлбэрт өгүүлэгдэхүүн болж буй ба үйлт нэрийн хэллэг бүхий бүтэц өгүүлбэрт энэхүү махбод хэлхэцийн цөм буюу орой болж үйлт нэрээр тодотгуулж байна.

Тү.

*Ben kitabi gordum* гол өгүүлбэр

*Sen kitabi yazdin* гишүүн өгүүлбэр

Ben [sfc senin yazdigin kitabi] gordum

Mo.

*Би ном харсан*- гол өгүүлбэр

*Чи ном бичсэн*- гишүүн өгүүлбэр

Би [үнхл чиний бичсэн номыг] харсан.

Энд харин түрэг хэлний *kitap* монгол хэлний *ном* хэмээх үг гол ба гишүүн өгүүлбэрийн хувьд дундын шинжтэй бөгөөд хоёр өгүүлбэрийн аль алиных нь хувьд шууд тусагдахуун болох ба зөвхөн сүүлчийн өгүүлбэрийн түрэг хэлний *kitap* монгол хэлний *ном* хэмээх шууд тусагдахуун хэлхэцийн цөм буюу орой болж байгаа юм. Бидний авч үзэж байгаа жишээнээс эхний гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн буюу түрэг хэлний *adam* монгол хэлний *хүн* хэмээх үг болон дараачийн гишүүн өгүүлбэрийн шууд тусагдахуун буюу түрэг хэлний *kitap* монгол хэлний *ном* гэх үг зүүнээс шилжиж хувиран үйлт нэр болсон махбод бөгөөд түрэг хэлний *geldi, yazdi* монгол хэлний *ирсэн, бичсэн* хэмээх үгийн баруун талд байршин гүн бүтцэд ул мөр хоосны айг үлдээж байгаа юм. Ийнхүү шилжиж хувирсан махбод ба ул мөрийн хооронд хам үзүүлэлт /co-indexation/ үүсчээ. Өөрөөр хэлбэл түрэг монгол хэлэнд үйлт нэрийн хэллэгтэй бүтэц өгүүлбэр гүн ба өнгөн бүтцийн гэсэн хоёр түвшинтэй байна

Энд түрэг монгол хэлний гол өгүүлбэрт шууд тусагдахуун болж буй түрэг хэлний *adam* монгол хэлний *хүн* хэмээх үг гишүүн өгүүлбэрт өгүүлэгдэхүүн болж буй ба үйлт нэрийн хэллэг бүхий бүтэц өгүүлбэрт энэхүү махбод хэлхэцийн цөм буюу орой болж үйлт нэрээр тодотгуулж буй түрэг хэлний *kitab* монгол хэлний *ном* хэмээх үг гол ба гишүүн өгүүлбэрийн хувьд дундын шинжтэй байж хоёр өгүүлбэрийн аль алиных нь хувьд шууд тусагдахуун болох ба зөвхөн сүүлчийн өгүүлбэрийн түрэг хэлний *kitab* монгол хэлний *ном* хэмээх шууд тусагдахуун хэлхэцийн цөм буюу орой болж байгаа бөгөөд энэхүү үйлт нэрийн хэллэгтэй бүтцэд түрэг хэлний *adam* монгол хэлний *хүн* хийгээд түрэг хэлний *kitab* монгол хэлний *ном* гэх үгс зүүнээс шилжиж хувиран үйлт нэр болсон махбод юм уу түрэг хэлний *geldi yazdi*, монгол хэлний *ирсэн, бичсэн* хэмээх үгийн баруун талд байршин гүн бүтцэд ул мөр хоосны айг үлдээж байгааг цөмийн хэмжигдэхүүний талаас нь анхаарах хэрэгтэй бөгөөд бидний дээр дурдсан жишээнд хэлхэцийн цөм ардаа байгаа түрэг монгол хэлний аль алинд нь шилжилт зүүнээс баруун тийш чиглэж байна. Харин Ф Карабүлүтийн гаргасан англи хэлний жишээг цөмийн хэмжигдэхүүний талаас ажиглахад хэлхэцийн цөм урдаа байх хэл болохын хувьд англи хэлний үйлт нэрийн хэллэгтэй бүтцэд *the man, the book* хэмээх хэлхэцийн орой буюу цөм болох махбодууд холбох төлөөний үг болж баруунаас зүүн тийшээ шилжиж тодорхой төлөвт хувилсан төгс өгүүлбэрийг нэр юм уу нэрийн хэлхэц болгож хувиргаж байгаагаараа түрэг монгол хэлнээс ялгарч байна.

## НОМЗҮЙ

- Цэрэнпил Д (2011), *Түгээмэл хэл зүй ба монгол хэл*, Улаанбаатар.  
Chomsky N (1981), *Lectures on Government and Binding*, Foris, Dordrecht.  
Cook V. J (1988), *Chomsky's Universal Grammar. An Introduction*. Basil Blackwell.  
Haegeman L (1994), *Introduction to Government and Binding theory*. Blackwell.  
Karabulut F (2009), *Kıçtırkenin Sıfat Fiilli Yapı Tipolojisi Bilig Kış* 2009 sayı 48:91-118  
Radford A (1988), *Transformational Grammar: A First Course*, Cambridge.

## SUMMARY

In this article author discusses on the Turkish, Mongolian and English facts about the relative clause constructions. According to author, head parameter differences in the relative clauses have emerged through certain transformations in three languages.